

Төрийн албаны зөвлөлийн
2020 оны 3 дугаар сарын 23-ны өдрийн
103 дугаар тогтоолын 19 дүгээр хавсралт

АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТ

I. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Албан тушаалын тодорхойлолт боловсруулсан үндэслэл

Төрийн албаны тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан шинэчлэн боловсруулсан

Хууль тогтоомжоор байгууллагын чиг үүрэгт өөрчлөлт орсон

Хууль тогтоомжийн нэр огноо:

Дагаж мөрдөх огноо:

Албан тушаалын тодорхойлолтыг баталсан огноо

Байгууллагын нэр:

Агаарын бохирдолтой тэмцэх газар

Нэгжийн нэр:

Агаарын чанар, хяналт, зохион байгуулалтын хэлтэс

Албан тушаалын нэр:

Орчны хэмжилт хариуцсан мэргэжилтэн

Албан тушаалын ангилал, зэрэглэл:

Дэс түшмэл, ТЗ-5

Ажлын цаг

Ажлын өдөр 8 цаг

Ажлын байрны албан ёсны байршил

Хангарди ордон, Ц.Жигжиджавын гудамж-7/1, Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот.

Хөдөлмөрийн нөхцөл:

Хэвийн

Онцгой нөхцөл

Хамаарахгүй

II. АЛБАН ТУШААЛЫН ЗОРИЛГО, ЗОРИЛТ, ЧИГ ҮҮРЭГ

Албан тушаалын зорилго:

Агаарын тухай хууль тогтоомж, стандартын дагуу орчны агаарын чанарыг хэмжигч явуулын AQMS-9000 хөдөлгөөнт харуулаар орчинд үзүүлж буй хорт нөлөөлөл, дотоод орчны бохирдлыг хэмжилт хийх, хэмжилтийн багаж хэрэгслүүдийн хэвийн үйл ажиллагааг хангах чиг үүргийн хүрээнд гүйцэтгэлийн үр дүнг хэлтсийн даргын өмнө хариуцна.

<u>Албан тушаалын зорилт:</u>			
1.Холбогдох стандартын дагуу гадаад дотоод орчинд хэмжилт хийх. 2.Орчны хэмжилтийн тоног төхөөрөмжүүдийн ашиглалт, найдвартай ажиллагааг хангах. 3.Байгууллага болон нэгжийн дотоод үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд шаардлагатай дэмжлэг үзүүлэх, хууль тогтоомжид заасан бусад чиг үүргийг хэрэгжүүлэх.			
Зорилт	Албан тушаалын гүйцэтгэх чиг үүрэг	Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	Хариуцлага, оролцооны хэлбэр Туслах - Т, Хариуцан гүйцэтгэх - Г Хянах -Х Шийдвэрлэх -Ш
1 дүгээр зорилтын хүрээнд	1.Агаарын чанарт нөлөөлөх аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд хэмжилт хийх төлөвлөгөөг боловсруулж, батлуулан хэрэгжилтийг хангах;	Мэдээллийн сан бүрдүүлсэн байна.	Г
	2.Хэмжилтийн дүн мэдээг боловсруулж, сар, улирал, жилээр мэдээллийн сан үүсгэж ажиллах;	Агаарын чанарын дүн мэдээ баталгаажсан байна.	Г
	3.Агаар бохирдуулагч суурин эх үүсвэр, хүрээлэн буй орчны хэмжилтийн дүн, мэдээллийн санд үндэслэн агаарын бохирдлыг бууруулах арга хэмжээний санал боловсруулах.	Үйл ажиллагааны ил тод байдал хангагдсан байна.	Г
	4.Иргэн, аж ахуйн нэгж байгууллагын өрөө, тасалгаа, үйлдвэр барилга байгууламжийн дотоод агаарын чанарын хэмжилт хийх, дүгнэлт зөвлөмж гаргах.	Байгууллагын чиг үүргийн хэрэгжилт хангагдсан байна.	Т,Г
2 дугаар зорилтын хүрээнд	1.Агаар орчны хэмжилтийн тоног төхөөрөмжүүдийн ашиглалтын горимын дагуу жил бүр засвар үйлчилгээ хийх хуваарийг батлуулж, хуваарийн дагуу засвар үйлчилгээ, тохируулгыг тогтмол хийлгэх;	Автомат суурин харуулын хэвийн үйл ажиллагаа хангагдсан байна.	Г
	2.Хэмжилтийн тоног төхөөрөмжийг шинэчлэх, эвдэрсэн төхөөрөмжийг	Автомат суурин харуулын хэвийн үйл ажиллагаа хангагдсан	Г

	засварлах, сэлбэг хэрэгсэл, урвалж бодисын зардлыг жил бүрийн байгууллагын төсөвт суулгах, санал оруулах.	байна.	
3 дугаар зорилтын хүрээнд	1.Нэгжийн үйл ажиллагааны эрсдэлийг бууруулах арга хэмжээний хэрэгжилтийг хангах;	Эрсдэл буурсан байна.	Г
	2.Бусад албан хаагчидтай албаны хэрэгцээт мэдээллээ шуурхай солилцох;	Мэдээлэл нь судалгаа, нотолгоотой бодитой байна.	Г
	3.Албан хэрэг хөтлөлтийн стандартыг мөрдөж, нэгжийн үйл ажиллагаанаас гарах баримтыг архивын холбогдох хууль журмын дагуу бүрдүүлж, хадгаламжийн нэгж болон цахим сан үүсгэн архивт хүлээлгэн өгнө;	Стандарт хангагдсан байна.	Г
	4.Өргөдөл гомдлыг хуулийн хугацаанд шийдвэрлэх;	Хуулийн хугацаанд шийдвэрлэсэн байна.	Г, Ш
	5.Хууль тогтоомжид заасан бусад чиг үүргийг хэрэгжүүлэх.	Хууль тогтоомжид заасан чиг үүрэг бүрэн хэрэгжсэн байна.	Г, Х
III.АЛБАН ТУШААЛД ТАВИГДАХ ТУСГАЙ ШААРДЛАГА			
Боловсрол	Бакалавр болон түүнээс дээш боловсролын зэрэгтэй.		
Мэргэжил	-хүрээлэн буй орчин судлал /0521/; -хүрээлэн буй орчныг хамгаалах технологи /0712/; -байгалийн шинжлэх ухаан /053/; -иргэний үйлдвэрийн барилга байгууламж /0732/.		
Мэргэшил	Төрийн албаны богино болон дунд хугацааны сургалтад хамрагдсан байна.		
Туршлага	Туслах түшмэлийн албан тушаалд 2-оос доошгүй жил ажилласан байх эсхүл мэргэжлээрээ 2-оос доошгүй ажил ажилласан байх		
	Дүн шинжилгээ хийх	<ul style="list-style-type: none"> - албан ажлын хэрэгцээнд шаардлагатай мэдээ мэдээллийг цуглуулж, дүн шинжилгээ хийх; - мэдээлэл дэх алдаатай нийцтэй бус байдлыг илрүүлэх; - эрсдэлийг үнэлэх, эрсдэлийг бууруулах арга хэмжээ авах; - бодлогын үндэслэлтэй санал, зөвлөмж, дүгнэлт боловсруулах; - бусад. 	

Ур чадвар	Асуудал шийдвэрлэх	<ul style="list-style-type: none"> - үндэсний язгуур эрх ашиг, сонирхолд захирагдан, ард түмэндээ үйлчилж, төрд үнэнчээр зүтгэх; - хууль тогтоомжийн хүрээнд ашиг сонирхлоос ангид шийдвэрлэх; - бусдын санал бодлыг сонсох, хүндэтгэх; - үүссэн нөхцөл байдлын эерэг болон сөрөг үр дагаврыг тооцох, санал боловсруулах; - асуудлыг эв зүйгээр шийдэх; - бусад.
	Багаар ажиллах	<ul style="list-style-type: none"> - өөрийн мэдлэг чадвар, мэдээллийг баг хамт олонтой хуваалцаж хамтран ажиллах; - бусадтай харилцан итгэл төрүүлэхүйц ажил хэрэгч, нээлттэй харилцааг бий болгох; - бусдын үзэл бодлыг сонсох; - маргаантай асуудалд хүлээцтэй, нийцтэй ханддаг байх; - бусад.
	Бусад	<ul style="list-style-type: none"> - англи хэл, эсхүл бусад гадаад хэлээр албан тушаалын чиг үүрэгт хамаарах мэдээллийг ашиглах чадвартай байх; - компьютерийн хэрэглээний программ, мэдээллийн орчин үеийн технологи ашиглах, мэдээллийг шуурхай солилцох; - төрийн албан хэрэг хөтлөлт, монгол хэлний зөв бичих, найруулга зүйн чадвартай байх; - байгууллага, хувь хүний нууцыг хадгалах.

IV. АЛБАН ТУШААЛТНЫ ХАРИЛЦАХ СУБЪЕКТ

Албан тушаалыг шууд харьяалан удирдах албан тушаалын нэр:

Газрын дарга, Орлогч дарга, Хэлтсийн дарга, Ахлах мэргэжилтэн.

Албан тушаалд шууд харьяалан удирдуулах албан тушаалын нэр, тоо:
Байхгүй

Бусад харилцах субъект:

- яам, агентлагийн холбогдох албан тушаалтан;
- нутгийн захиргааны болон нутгийн өөрөө удирдах байгууллагын холбогдох албан тушаалтан;
- төрийн болон төрийн бус байгууллага;
- иргэн, хуулийн этгээд.

V. АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТЫН БАТАЛГААЖУУЛАЛТ

Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан:

Албан тушаалын тодорхойлолтыг хянаж, батлах зөвшөөрөл олгосон байгууллагын шийдвэр:

Албан тушаал:
ЗАХИРГААНЫ ХЭЛТСИЙН ДАРГА
О. Агвагзор, О. Агвагзор
2020 оны 04 дугаар сарын 21-ны өдөр

Байгууллагын нэр:
ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛ
Шийдвэрийн огноо: 20 03 23
Дугаар: 103

Албан тушаалын тодорхойлолтыг баталсан:

Байгууллагын нэр:

АГААРЫН БОХИРДОЛТОЙ ТЭМЦЭХ ГАЗАР

Шийдвэрийн огноо: 2020.04.21

Дугаар: А/42

(тамга/тэмдэг)

АГААРЫН БОХИРДОЛТОЙ ТЭМЦЭХ

ГАЗРЫН ДАРГА

2020 оны 04 дугаар сарын 21-ны өдөр

